



ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2025 он

**ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ 2024 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН****ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО**

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь төрийн бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад оршино.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт хамаарах бодлогын баримт бичиг, холбогдох эрх зүйн акт болон яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, байгууллагын ил тод байдал, Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримтлан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын явцад зарим тайлан, мэдээллийн хэрэгжилтийн байдалд нэмэлт тодруулга авах, асуудал хариуцсан нэгжээс тайлбар авах зэргээр мэдээллийн чанарыг сайжруулах, бататгах ажлыг гүйцэтгэв.

ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2024 оны үйл ажиллагааг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6 дугаар хавсралтын дагуу дүгнэхэд ерөнхий үнэлгээ **94.0** хувь буюу **4.70** оноотой байна.

Хүснэгт 1

Үзүүлэлт		Хувь	Оноо
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	85.2	4.26
	2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	88.5	4.43
	3. Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт	94.0	4.70
	4. Салбарын хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	98.4	4.92
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1. Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	95.0	4.75
	2. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт	98.6	4.93
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	98.5	4.93
	2. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	-	-
	3. Шударга байдлын түвшний үнэлгээ /АТГ/	-	-
	4. Хэрэглэгчийн үнэлгээ	-	-
Ерөнхий үнэлгээ		94.0	4.70

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

1.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Монгол Улсын хууль 23, Улсын Их Хурлын тогтоол 25, Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол 15, Ерөнхийлөгчийн зарлиг 6, Засгийн газрын тогтоол 79, Ерөнхий сайдын захирамж 3, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 65, Засгийн газрын албан даалгавар 5 нийт 195 шийдвэрийн 475 заалт байна.

2024 оны жилийн эцсийн байдлаар гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт хэрэгжүүлэх хууль тогтоомжийн хэрэгжилт:

Монгол Улсын хууль - 84.4 хувь

Улсын Их Хурлын тогтоол - 86.6 хувь

Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол - 85.2 хувь

Ерөнхийлөгчийн зарлиг - 70.0 хувь

Засгийн газрын тогтоол - 88.2 хувь

Ерөнхий сайдын захирамж - 85.0 хувь

Засгийн газрын хуралдааны тэмдэглэл - 84.3 хувь

Засгийн газрын албан даалгавар - 75.3 хувь

Салбарын хууль тогтоомж, тогтоол шийдвэр 2024 оны жилийн эцсийн байдлаар 85.2 хувийн биелэлттэй хэрэгжсэн байна.

Монгол Улсын хууль, УИХ-ын шийдвэр,
Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын
шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээ

Хүснэгт 2

		Нийт	МУ-ын хууль	УИХ-ын тогтоол	УИХ-ын байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	ЗГ-ын тогтоол	ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	Засгийн газрын албан даалгавар	Ерөнхий сайдын захирамж
Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо		195	23	25	15	6	79	65	5	3
Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо		475	103	73	60	99	89	118	19	44
Бүрэн хэрэгжсэн	100%	237	72	46	31	4	54	70	4	2
Хэрэгжих шатанд	70%	100	6	13	19	1	22	27	10	2
Хэрэгжилт хангалтгүй	30%	42	11	7	3	3	4	13	1	-
Хэрэгжээгүй	0%	4	4	-	-	-	-	-	-	-
Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй		46	10	7	7	1	9	8	4	-
Биелэлтийн дундаж хувь		85.2	85.4	86.6	85.2	70.0	88.2	84.3	75.3	85.0

Салбарын эрх зүйн актын хэрэгжилтийн тайлан мэдээллийг Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан www.unelgee.gov.mn-д оруулан баталгаажуулсан.

1.2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд хариуцан хэрэгжүүлэх 57 зорилтын хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Нийт үнэлгээгээр Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд туссан гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилт 2024 оны жилийн эцсийн байдлаар **88.5** хувийн биелэлттэй байна.

*Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын
2024 онд хэрэгжүүлсэн арга хэмжээний
хэрэгжилт*

Хүснэгт 3

Зорилтын тоо	Хэрэгжилт /хувиар/			
	100 %	90 %	70%	Хугацаа болоогүй
57	20	7	13	17
Дундаж - 88.5 %				

Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд хариуцан хэрэгжүүлсэн 54 зорилт 2024 оны жилийн эцсийн байдлаар “тодорхой үр дүнд хүрсэн” байна.

1.3 Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хамаарах 5 зорилт, арга хэмжээ туссан байна.

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд туссан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсөл, арга хэмжээний хэрэгжилт 2024 жилийн эцсийн байдлаар **94.0** хувийн үнэлгээтэй буюу “тодорхой үр дүнд хүрсэн” байна.

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ
Монгол Улсын хөгжлийн 2024 оны
төлөвлөгөөний хэрэгжилт

Хүснэгт 4

Зорилго	Зорилт	Зорилтын биелэлтийн хувь	Зорилгын биелэлтийн хувь
3.2.Нийгмийн хамгааллын салбарт нийгмийн даатгалын оновчтой тогтолцоог бий болгох, төрийн албан хаагчдын цалинг үе шаттайгаар нэмэгдүүлэх, нийгмийн зорилтот бүлгийг зөв тодорхойлж, нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэн нийгмийн баталгааг сайжруулна.	3.2.1.Нийгмийн даатгалын тогтолцоог өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн нийт хувь нэмрээс хамааруулан тэтгэврийг оновчтой тогтооно.	100.0	94.0
	3.2.2.Үр дүнд суурилсан удирдлагын нэгдсэн тогтолцоог бүрэн нэвтрүүлэн, төрийн албаны бүтцийн шинэчлэлийг хийж, төрийн албан хаагчдын цалин хөлсийг ажлын бүтээмж, үр дүнтэй уялдуулан нэмэгдүүлнэ.	100.0	
	3.2.3.Цалинг цагаар тооцдог системд бүрэн шилжинэ.	70.0	
	3.2.4.Нийгмийн халамжийн системийг шинэчлэн, халамж зайлшгүй хүртэх зорилтот бүлгийг оновчтой тодорхойлж, халамжийг зөвхөн тусгайлсан картаар олгоно	100.0	
	3.2.5.Тэтгэвэр, тэтгэмжийг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлнэ.	100.0	

Төсвийн Ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр төслийн хэрэгжилт:

Хүснэгт 5

	Төсөл, хөтөлбөр	Гүйцэтгэлийн хувь
3.2	Нийгмийн баталгааг сайжруулна.	100
3.2.1	Тэтгэврийн насны хүн амын нийгмийн баталгааг дээшлүүлнэ	100
3.2.1.1.	Нийгмийн даатгалын шударга тогтолцоонд шилжүүлэх	100
3.2.1.2.	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх	100
3.2.2.	Зорилтот бүлгийн нийгмийн баталгааг дээшлүүлнэ.	93.3
3.2.2.1.	Зорилтот бүлгийг зөв тодорхойлж, нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх	100
3.2.3.1	Төрийн албан хаагчдын цалинг үе шаттайгаар нэмэгдүүлэх	100
7.3.1.	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн аюулгүй байдал хангагдана.	100

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын Төсвийн ерөнхийлөн захирагч дээрх төсөл, арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлснээр нийгмийн даатгалын сангийн тогтвортой, бие даасан байдлыг хангах, нийгмийн даатгалд даатгуулах ач холбогдлыг нэмэгдүүлэх, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах үйлчилгээний нөхцөлүүдийг даатгуулагчид ээлтэй байдлаар сайжруулсан ба ингэснээр иргэдийн амьдралын чанарт эерэг нөлөө үзүүлж байна.

Мөн нийгмийн даатгал, халамжийн сангаас олгодог тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлснээр тэтгэвэр авагчийн тэтгэврийг өнөөгийн үнэ цэнд хүргэж тэтгэвэр авагчийн нийгмийн баталгааг хангах,

ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хагас, бүтэн өнчин хүүхэд, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон асаргааны тэтгэмж авдаг зэрэг нийгмийн халамж зайлшгүй шаардлагатай иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлж, иргэдийн амьжиргааг дээшлүүлэхэд томоохон дэмжлэг болсон байна.

Түүнчлэн төрийн албан хаагчдын цалинг үе шаттайгаар нэмэгдүүлснээр төрийн албан хаагчид, ялангуяа орон нутагт ажиллаж байгаа төрийн албан хаагчид тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдэж, амьдралын чанар дээшлэхэд тодорхой санхүүгийн дэмжлэг болж байна.

1.4 Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2024 оны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны эдийн засаг, нийгмийн хөгжлийн 19 үзүүлэлт 2024 оны жилийн эцсийн байдлаар **98.4** хувийн биелэлттэй байна.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2024 оны эдийн засаг, нийгмийн хөгжлийн 16 үзүүлэлт зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, 3 үзүүлэлт 86.9-98.8 хувийн биелэлттэй байна.

Боловсролын яаманд Мэргэжлийн боловсрол, сургалтын 2, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яаманд Залуучуудын хөгжлийн 1 үзүүлэлт чиг үүргийн хүрээнд шилжин үнэлэх боломжгүй байна.

Үнэлгээний дундаж хувийг тооцоходоо үнэлэх боломжгүй арга хэмжээг оруулан тооцоогүй болно.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг үндэслэн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2024 оны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтүүдийн гүйцэтгэлд дараах дүгнэлт, зөвлөмжийг өгч байна. Үүнд:

1. Тус яам нь Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр тусгагдсан бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлсний хүрээнд 2024 оны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтүүд 98.4 хувьтай биелсэн байна.
2. Хэрэгжүүлсэн хууль эрх зүй, санхүү, хүний нөөцийн бодлогын үр дүнд өрхийн амьжиргааг дээшлүүлэхэд чухал үүргийг гүйцэтгэдэг ажиллагчдын цалин хөлс, нийгмийн даатгалын сан болон халамжийн сангаас олгодог тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдлийн түвшин зэрэг шалгуур үзүүлэлтүүд 2024 оны зорилтод түвшиндээ бүрэн хүрсэн байна.
3. Үзүүлэлтүүдийг яам болон харьяа байгууллагуудын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдах арга хэмжээний хүрэх үр дүнтэй холбох, төлөвлөгөөний биелэлтийг гаргах бүрт эдгээр үзүүлэлтүүдийн хүрсэн түвшинг тодорхойлж байх.

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ
Эдийн засаг, нийгмийн хөгжлийн
үзүүлэлтийн биелэлт

Хүснэгт 6

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны суурь үзүүлэлт	2024 оны зорилтот түвшин	2024 оны гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь	Үнэлгээ
1	Ажиллах хүчний оролцооны түвшин /хувь/	хувь	59	62.5	63 /3 улирал/	100	100
2	Эдийн засгийн идэвхтэй хүн ам (ажиллах хүч)-ын нийгмийн даатгалд хамрагдсан хувь	хувь	77.5	87.5	92.0	100	100
3	Ажилгүйдлийн түвшин /хувь/	хувь	7.3	8	6.1 /3 улирал/	100	100
4	Шинээр бий болсон ажлын байрны тоо	мян.хүн	29.5	36.7	31.9	86.9	90
5	Төгсөөд шууд ажил эрхэлж буй төгсөгчдийн нийт төгсөгчдөд эзлэх хувь (МСҮТ, Политехник коллеж)	хувь	51.5	БЯ-нд чиг үүрэг нь шилжсэн			
6	МБСБ-д элсэгчдийн тоо	мян.хүн	22.7				
7	Тэтгэвэр, тэтгэмжийн өсөлт	хувь	8.0	6.0	6.0	100	100
8	Халамжийн тэтгэврийн хэмжээ /НХС/	мян.төг	188.0	237.3	375.0	100	100
9	Дундаж тэтгэврийн хэмжээ /НДС/	мян.төг	417.5	456.0	848.0	100	100
10	Нийгмийн даатгалд хамрагдалтын байдал						
	Ажил олгогч	мян.хүн	48.7	50.2	60.6	100	100
	Албан журмын даатгуулагчийн тоо	мян.хүн	916.9	963.5	1161.3	100	100
	Сайн дурын даатгуулагчийн тоо	мян.хүн	183.8	193.2	171.3	88.7	90
	Цахим үйлчилгээний тоо /НД/	тоо	6	72	72	100	100
11	Төсөвт байгууллагын сарын дундаж	мян.төг	1058.1	1224.7	2326.0	100	100

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

	цалингийн хэмжээ						
12	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчилж, бага орлоготой иргэдийн орлогыг нэмэгдүүлэх	мян.төг	420.0	483.0	660.0	100	100
13	Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд урьдчилан сэргийлэх болон хамгааллын хариу үйлчилгээ үзүүлсэн хувь	хувь	5.5	97	100	100	100
14	Хүүхдээс хүлээж авсан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь	хувь	99	99	97.9	98.8	90
15	Хүүхдийн зусланд хамрагдсан хүүхдийн тоо	мян.хүн	70.0	90.0	91.8	100	100
16	Гэр бүлд зөвлөгөө өгөх төвөөр үйлчлүүлсэн хүн	хувь	45	33	34	100	100
17	Ахмадын ордон, өргөө, танхим, төвд үйлчлүүлсэн болон зөвлөгөө мэдээлэл авсан ахмад настны хувь	хувь	90	92	93.4	100	100
18	Залуучуудын хөгжлийн төвөөр үйлчлүүлсэн залуучуудын тоо	хувь	45	45	ССАЖЗЯ-нд чиг үүрэг шилжсэн		-
19	Сэргээн засах үйлчилгээнд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо	мян.хүн	9.6	14	16.9	100	100
20	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2024 оны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтүүдийн дундаж үнэлгээ						98.4

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ
ХОЁР. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

2.1. Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт

ГБХНХЯамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримтлан хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгч ажиллалаа.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бодлогын баримт бичигт тусгагдсан, хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах 3 зорилтын нийт 155 арга хэмжээ туссан байна.

Үүнээс:

- Бүрэн хэрэгжсэн 100 хувьтай - 117 арга хэмжээ,
- 90 хувьтай 24 арга хэмжээ,
- 70 хувьтай 9 арга хэмжээ,
- 50 хувьтай 1 арга хэмжээ,
- 30 хувьтай 3 арга хэмжээ,
- УИХ-ын ээлжилт сонгуультай холбоотойгоор 1 арга хэмжээний хэрэгжих хугацаа хойшлогдсон байна.

Үнэлгээний дундаж хувийг тооцохдоо хойшлогдсон арга хэмжээг оруулан тооцоогүй болно.

Яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт **95.0** хувьтай үнэлэгдлээ.

Үнэлгээг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ тус бүрээр харуулбал:

Зорилт, арга хэмжээний хэрэгжилт

1. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээнд 51 арга хэмжээ туссанаас 36 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, 90 хувьтай 9 арга хэмжээ, 70 хувьтай 3 арга хэмжээ, 50 хувьтай 1 арга хэмжээ, 30 хувьтай 1 арга хэмжээ, хугацаа болоогүй хойшлогдсон 1 арга хэмжээ байна. Хэрэгжилтийн дундаж үнэлгээ 94.0 хувь байна.
2. Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээнд 88 арга хэмжээ туссанаас 70 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, 90 хувьтай 12 арга хэмжээ, 70 хувьтай 4 арга хэмжээ, 30 хувьтай 2 арга хэмжээ байна. Хэрэгжилтийн дундаж үнэлгээ 95.7 хувь байна.
3. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээнд 16 арга хэмжээ туссанаас 11 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, 90 хувьтай 3 арга хэмжээ, 70 хувьтай 2 арга хэмжээ байна. Хэрэгжилтийн дундаж үнэлгээ 94.4 хувь байна.

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ
Зорилт, арга хэмжээний хэрэгжилт

Хүснэгт 7

№	Зорилтын төрөл	Арга хэмжээ	Гүйцэтгэлийн үнэлгээ / хувиар /						Дундаж хувь
			100	90	70	50	30	ХБ	
1	Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ	51	36	9	3	1	1	1	94.0
2	Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ	88	70	12	4	0	2	-	95.7
3	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээ	16	11	3	2	-	-	-	94.4
Нийт		155	117	24	9	1	3	1	95.0

2.2. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт

Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2024 оны хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримтлан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2 зорилт, 7 үйл ажиллагаа 2024 оны жилийн эцсийн байдлаар бүрэн хэрэгжсэн буюу 100 хувийн биелэлттэй 6, 90 хувийн биелэлттэй 1 үйл ажиллагаа байна.

Нийт үнэлгээгээр Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааны хэрэгжилт 2024 оны жилийн эцсийн байдлаар **98.6** хувьтай байна.

Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтийг зорилт тус бүрээр харуулбал:

- Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх зорилтын 3 үйл ажиллагаа 96.6 хувь,
- Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зорилтын 4 үйл ажиллагаа 100.0 хувь үнэлэгдлээ.

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ
ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

3.1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2024 оны ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу үнэллээ.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны ил тод байдлын 5 хэсгийн 46 шалгуур үзүүлэлт 2024 оны жилийн эцсийн байдлаар **98.5** хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт 8

№	Шалгуур үзүүлэлт	Шалгуур үзүүлэлтийн тоо	Хэрэгжилт /хувиар/
1	Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	10	97.1
2	Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал	6	95.1
3	Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	15	100.0
4	Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	2	100.0
5	Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал	13	100.0
Нийт		46	98.5

- "Бүрэн хэрэгжсэн" - холбогдох шийдвэр гарч тавьсан зорилтдоо бүрэн хүрсэн, үр дүн гарсан буюу 100 хувийн хэрэгжилттэй - 38 арга хэмжээ;
- "Хэрэгжих шатанд" - тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч төсөв, санхүүгийн асуудлыг шийдсэн, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, дээд шатны байгууллагад өргөн барьсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч байгаа буюу 70 хувийн хэрэгжилттэй - 2 арга хэмжээ;
- "Үнэлэх боломжгүй" - 1 шалгуур үзүүлэлт байна.

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭГЭЭР
ӨГСӨН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

Нэг. ДҮГНЭЛТ

Үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт заасан чиг үүргийн хүрээнд “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр тусгагдсан томоохон бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллалаа. Тэдгээрээс заримыг дурдвал:

- Хөдөлмөр эрхлэлтийн цогц үйлчилгээг үзүүлэх олон улсын жишигт нийцсэн, ижил стандарт бүхий “Job center” төвийн үйл ажиллагааг эхлүүллээ.
- Төрийн албаны цалин хөлсний тогтолцоог шинэчилж цалин хөлсийг ажилласан жил, бүтээмж, хүрсэн үр дүнтэй уялдуулан 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг 20 хувиар, бусад төрийн албан хаагчдын цалинг 10 хувиар нэмэгдүүллээ.
- Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэвэр болон халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоолоо.
- Хөдөлмөр эрхлэлтийн бодлого, ажлын байр бий болгохыг дэмжих, хадгалах чиглэлээр нийт 6 хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж байна.

Хоёр. ЗӨВЛӨМЖ

Нэг. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн талаар:

- ✓ Хэрэгжилт хангалтгүй болон хэрэгжээгүй арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах;
- ✓ Төрийн эрх бүхий байгууллагууд хамтран баталж, хэрэгжүүлэх эрх зүйн актыг тогтоосон хугацаанд нь батлан хэрэгжүүлэхэд анхаарах;
- ✓ Тайлангийн үг, үсэг, утга найруулгын алдааг газар, хэлтсийн даргаар хянуулан баталгаажуулж, заасан хугацаанд Төрийн захиргааны удирдлагын газарт ирүүлэх;
- ✓ Хэрэгжилтийг тухайн зорилт, арга хэмжээ, заалтын гүйцэтгэл, үр дүнг хоёр мянган тэмдэгтэд багтаан тайлагнах;
- ✓ Хууль тогтоомж, тогтоол шийдвэрээр өгсөн үүрэг даалгаврыг хяналтад авч, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;
- ✓ Тайлант үеийн хэрэгжилтийг ирүүлээгүй, өмнөх тайланг хуулж тавьсан, худал, зөрүүтэй тайлагнасан, өгсөн дүгнэлт, зөвлөмжийг биелүүлээгүй, хугацаа хоцроосон зэрэг зөрчил дутагдал гаргасан албан хаагчдад холбогдох хууль, журмын дагуу хариуцлага тооцох талаар Засгийн газрын 2022 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны 41 дүгээр тэмдэглэлээр үүрэг болгосныг хэрэгжүүлж ажиллах.

Хоёр. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар:

- ✓ ЗГҮАХ-т тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлтэд бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах.
- ✓ Яамны холбогдох нэгжийн удирдлагууд зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, хэрэгжилт удаашралтай, эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээний шалтгаан, нөхцөлийг тодорхойлж, үр дүнг сайжруулах талаар цаг тухай бүрт арга хэмжээ авч, 2025 оны тухайн жилийн зорилтот түвшинд хүргэж ажиллах шаардлагатай байна.

Гурав. Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийн талаар:

- ✓ Хэрэгжилтийг тайлагнахдаа шалгуур үзүүлэлттэй нь уялдуулж, үр дагаврыг үнэлж, тухайн арга хэмжээнд зарцуулсан хөрөнгө, санхүүжилтийн гүйцэтгэлийг эх үүсвэр тус бүрээр бодитой тайлагнах;

- ✓ Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний зорилт, арга хэмжээг яамны холбогдох газрууд хяналтад авч, сар бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрэх түвшин, хэрэгжүүлэх хугацааг тусган төлөвлөж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;
- ✓ Хяналт-шинжилгээ, үнэлгээнээс гарсан дүгнэлт, зөвлөмжийн хүрээнд хариуцлагыг сайжруулж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах.

Дөрөв. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээний талаар:

- ✓ Үзүүлэлтүүдийг яам болон харьяа байгууллагуудын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдах арга хэмжээний хүрэх үр дүнтэй холбох, төлөвлөгөөний биелэлтийг гаргах бүрт эдгээр үзүүлэлтүүдийн хүрсэн түвшинг тодорхойлж байх.

Тав. Байгууллагын ил тод байдлын үнэлгээний талаар:

- ✓ Нээлттэй мэдээллийн ил тод байдлыг хангахад Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолоор батлагдсан “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих журам”-ыг мөрдөж ажиллах;
- ✓ Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор батлагдсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-д заасны дагуу Мэдээллийн хүртээмжтэй байдал, Хугацаандаа нийтэлсэн байдал, Мэдээллийн бүрэн бүтэн байдал, Эх сурвалж тодорхой байдал зэрэг шалгууруудыг ханган ажиллах;
- ✓ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.12-т заасны дагуу байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарыг тогтмол ажиллуулж, олон нийтийг нээлттэй мэдээлэлтэй танилцах нөхцөлийг бүрэн хангаж ажиллах;
- ✓ Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/175 тоот тушаалаар баталсан “Мэдээллийн ил тод байдлыг хангах, мэдээлэл хариуцах албан тушаалтныг томилох тухай” тушаалын хэрэгжилтийг хангаж, нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, журмын хэрэгжилтийг хангах, зохион байгуулалтаар хангаж ажиллах, албан тушаалтнуудын төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжилтийг газар, хэлтсийн дарга нар хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллах;
- ✓ Хэрэгжилтийн явцад хяналт тавих, үйл ажиллагааг эрчимжүүлэх, хариуцлагыг сайжруулж удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах.

Зургаа. Яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн талаар:

- ✓ Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан журамд заасан хугацаанд боловсруулж, батлуулах;
- ✓ Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бүрэн тусгах талаар хяналт тавьж ажиллах;
- ✓ Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 4.4-т “...Бодлогын баримт бичиг болон түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

төлөвлөгөө боловсруулах шатанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ажилтан, нэгжээс төлөөлөл оруулан хамтран ажиллана” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах;

- ✓ Хэрэгжээгүй арга хэмжээг 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах;
- ✓ Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд явцын хяналт тогтмол тавьж хэрэгжилт удаашралтай арга хэмжээний шалтгаан нөхцөлийг тодорхойлж, үр дүнг сайжруулах талаар цаг тухай бүрт арга хэмжээ авч ажиллах;
- ✓ Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг шалгуур үзүүлэлттэй нь уялдуулж, үр дүнд чиглэсэн, товч, тодорхой байдлаар хоёр мянган тэмдэгтэд багтаан хугацаанд нь тайлагнах;
- ✓ Газар, нэгжийн дарга нар гүйцэтгэлийн тайланг хянан баталгаажуулж ТЗУГ-т ирүүлэх;
- ✓ Хяналт-шинжилгээ, үнэлгээнээс гарсан дүгнэлт, зөвлөмжийн хүрээнд хариуцлагыг сайжруулж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах.

Хавсралт

1. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, танилцуулга
2. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээний тайлан, танилцуулга
3. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлтийн үнэлгээний тайлан, танилцуулга
4. Байгууллагын ил тод байдлын үнэлгээний тайлан, танилцуулга

ТАНИЛЦСАН:

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.МӨНХЗУЛ

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА

Ц.МӨНХЗУЛ